

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр, Лхагва гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-15
<hr/>	
<b>1.Элчин сайдыг томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/</b>	4-11
<b>2.“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</b>	11-15

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 27 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Жангабыл;  
Чөлөөтэй: Э.Болормаа, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Наранбаатар, Ө.Шижир, Б.Энхбаяр,  
Р.Эрдэнэбүрэн.

**Нэг.Элчин сайдыг томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр, Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын газрын захирал Д.Булган, мөн яамны Бодлогын газрын дэд захирал Д.Бямбадорж, Консулын газрын дэд захирал Т.Бат-Орших, Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Н.Оюундарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Ганбат нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Н.Оюундарь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 2

Бүгд: 17

88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 94.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** *“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Т.Наранхүү, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Гадаад хамтын ажиллагааны газрын Олон улсын гэрээ, эрх зүй, ёслолын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Сэргэлэнбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 3  
Бүгд: 17  
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 36 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр,  
Лхаав гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
13 цаг 27 минут.

### **АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооныхоо гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Шинэ оны анхны хуралдаан бас эхлэх гэж байна. Гишүүддээ шинэ оны мэнд хүргэе.

Гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Ингээд 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаан нээснийг та бүхэндээ мэдэгдэж байна. Өнөөдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар танилцуулах асуудал хэлэлцэх асуудлыг танилцуулъя та бүхэнд. Хоёр асуудал байгаа.

Нэгдүгээрх нь Элчин сайдыг томилох асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 12 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн зөвшилцөх байгаад байгаа.

Хоёр дахь асуудал нь “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Мөн Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн соёрхон батлахаар байгаад байгаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байгаа юу?

Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Нэгдүгээр асуудал. Элчин сайдыг томилох асуудлаар зөвших тухай асуудлыг хэлэлцье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэг болон албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Эрдэнэцогтын Одбаяр хүрэлцэн ирсэн байна. Мөн Гадаад харилцааны сайд Батцэцэг сайд хүрэлцэн ирсэн байгаа. Мөн Гадаад харилцааны яамны

Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын газрын захирал Дансрангийн Булган. Ажлын хэсгийг оруулаарай танхимд. Мөн тус яамны Бодлогын газрын дэд захирал Доньжчимбуугийн Бямбадорж, мөн тус яамны Консулын газрын дэд захирал Төмөрбаатарын Бат-Орших, тус яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамбалдоржийн Соёлмаа нар хүрэлцэн ирсэн байна.

Мөн Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдаар томилогдох албан тушаалтныг танилцуулъя. Наваан-Юндэнгийн Оюундарь Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч байгаа.

Ингээд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайдыг томилох асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Одбаяр танилцуулна. Таныг микрофонд урьж байна. 3 номер.

**Э.Одбаяр:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг шинээр томилох саналыг танилцуулж байна.

Наваан-Юндэнгийн Оюундарийг Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилох асуудлыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын гишүүд дэмжсэн болно.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс, олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, Монгол Улсын ашиг сонирхол болон Монгол Улсын эрхийг хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгааг хийж төр засгийн байгууллагуудыг мэдээллээр бүрэн хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар яриа, хэлэлцээ хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн болон хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна, тэргүүлж буй Элчин сайдын яамныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэй байдаг билээ.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй Наваан-Юндэнгийн Оюундарь нь төрийн албанд олон жил ажилласан, дипломат албанд ажилласан туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, Орос, Англи хэлний мэдлэгтэй, Герман, Хятад хэлний бас мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан төрийн тусгай албанд ажиллах бүрэн боломжтой албан хаагч гэж үзэж байгаа болно.

Иймд Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Элчин сайдыг шинээр томилох Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн саналыг зөвшилцөн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Одбаяр зөвлөхөд баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчээс асуулт асуух асуулттай гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Ганбат гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Т.Энхтүвшин:** Нэр дэвшигчээс асуулт байна 1 асуулт. Тэгээд яамнаас 1 асуулт байгаа.

Ер нь гадаад харилцааны Элчин сайдуудын яамнуудын гол үүргүүдийн нэг нь энэ эдийн засгийн харилцааг өргөжүүлэх чухал ач холбогдолтой гэж бодож байгаа. Тэгээд манай эдийн засгийг хөгжүүлэхийн тулд ялангуяа том зах зээлүүд рүү зорих ёстой. Тэгэхээр яг энэ Польш Улстай Монгол Улсын хувьд эдийн засгийн харилцаан дээр ямаршуу боломжууд экспорт талаасаа, хөрөнгө оруулалт талаасаа Польшийн хувьд бол миний ойлгож байгаагаар бол бас Европтоо аж үйлдвэрлэлийн нэлээн том боломжтой, ялангуяа ур чадвар, энэ ажиллах хүчин сургах энэ ур чадвар, энэ ноу хау шилжүүлэх тал дээр бас нэлээн том боломжууд байгаа юм уу гэсэн бодол байгаа. Тэгээд энэ дээр таны санал бодлыг сонсьё гэж бодож байна.

Хоёрдугаарт, Гадаад хэргийн яамнаас элчин сайдуудтай холбоотой энэ бас тодорхой хэмжээний нөгөө улс төрийн албан тушаалтан ч юм уу, улс төрийн чиг үүрэгтэй хүмүүс Элчин сайдуудаар нэлээн томилогддог. Тэгээд энэ харьцаан дээр Гадаад хэргийн яам ямаршуу бодлого барьж ажиллаж байгаа вэ? Энэ харьцаа нь ямаршуу байдалтай байгаа вэ гэдэг ийм 2 асуулт байна.

**Г.Тэмүүлэн:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Оюундарь, 2 номер.

**Н.Оюундарь:** Эрхэм гишүүн Энхтүвшиний асуултад хариулъя.

Ерөнхийдөө бол Монгол, Польшийн харилцаа ялангуяа эдийн засгийн харилцаа бол маш их өргөжин хөгжиж байгаа. Сүүлийн 3 жилийн хугацаанд 2 дахин эдийн засгийн эргэлт нь нэмэгдсэн байгаа. Үндсэндээ бол худалдааны эргэлт 100-гаад сая ам.доллар-ын хэмжээнд хүрсэн. Энэ маань өөрөө бол бодит цаашаага ч өсөх ийм өндөр магадлал бүхий байгаа гэж үзэж байна.

Нөгөө талаасаа бид нар Польшоос экспортолж байгаа бараа, бүтээгдэхүүн нь маш ихээр байдаг. Тухайлбал гэхэд хүнсний бүтээгдэхүүн, барилгын материал, химийн бүтээгдэхүүн зэрэг бараа материалуудыг экспортолдог.

Ерөнхийдөө бол эдийн засгийн хувьд бол Европын холбоо дотроо дээрээсээ гуравт ордог ийм эдийн засаг. Манайх Польш өөрөө Герман болон Швейцарын дараа ордог ийм Монголтой харилцаа холбооны хувьд ийм байдалтай байж байдаг.

Худалдааны эргэлтээсээ гадна хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр нэлээдгүй үйл ажиллагаа явуулдаг. Сая тухайлбал Анджей Дуда Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд Монгол, Польшийн бизнес форумыг зохион байгуулсан. Бизнес форумд айлын талаас 20-иод компанийн 40-өөд төлөөл, бизнесийн төлөөлөгчид, манай Монгол Улсаас 100 гаруй төлөөлөгчид оролцож харилцан хамтарч ажиллах талаар харилцан яриа хэлэлцээнүүдийг хийж байсан. Ерөнхийдөө боломж бол маш их байгаа. Тэнд 100-гаад Монгол иргэд амьдардаг. Тэр маань бол гол төлөв дандаа анагаах ухааны чиглэлийн, уламжлалт анагаах ухааны чиглэлээр ажилладаг улсууд.

Тэгэхээр Монголоос анагаахын чиглэлийн уламжлалт эм, эмийн бүтээгдэхүүн эд нар экспортолдог, ноос, ноолуур, малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортолдог. Мөн зарим архи, дарс бас Польш руу манай Монголоос экспортолдог. Ерөнхийдөө бол хөдөө аж ахуйн чиглэлээр нэлээд их хамтын ажиллагаа хийх илүү их боломж, бололцоо нь бас байгаад байдаг юм байна лээ. Манайх 30 гаруй Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан. Энэ хэлэлцээрүүдийн хүрээнд ялангуяа барилгын салбар, ялангуяа тэр тусмаа барилгын салбар, хөдөө аж ахуйн салбар, эм, эмийн бүтээгдэхүүн, анагаах ухааны салбар, эрүүл мэндийн салбар гэх мэтээр ингээд харилцаануудыг бол цааш нь хөгжүүлэх боломж, бололцоо бол нэлээд байгаа гэж ойлгож байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Батцэцэг сайд асуултад нэмж хариулъя. Батцэцэг сайдын микрофоныг өгье.

**Б.Батцэцэг:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө манай томилогдчихсон байгаа яг дипломат төлөөлөгчийн газрууд 50 байгаа, 50 хүрсэн байгаа. Энэ жил 34 Элчин сайдын яам байгаа юм. Тэгээд Байнгын төлөөлөгчийн газар, Худалдааны төлөөлөгчийн газар, Ерөнхий консулын газар, Консулын газар гээд нийтдээ 50 ДТГ байгаа. Дипломат төлөөлөгчийн газар.

Яг тэргүүнүүдийнх нь хувьд бол Элчин сайд нарын томилгоо дээр сүүлийн 4 жилд томилогдсон томилгоо бол нэлээн мэргэжлийн болсон гэж хэлж болно. 22 хувь мэргэжлийн бус буюу улс төр, бусад салбараас улс төрийн шийдвэр гаргаад явсан ийм Элчин сайд нар байгаа.

Гадна өөр байгууллагуудаас явсан Элчин сайд нар бол ихэвчлэн төрийн албаны бас дадлага туршлагатай, удирдах ажлын дадлага туршлагатай, улс төрийн зарим нь бас тодорхой туршлагатай ийм хүмүүсээс бүрдсэн байгаа. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнээс гадна бусад дотор нь ажиллаж байгаа ажилтнуудын хувьд бол ихэвчлэн Гадаад харилцааны яамнаас байдаг.

Гэхдээ бусад зарим мэргэжлийн байгууллагуудаас бас томилгоо хийгддэг. Энэ нь бараг 30 орчим хувь байгаа. Тэгээд энийг бас илүү мэргэжлийн болгох ийм шаардлага цаашдаа байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Энхбаяр гишүүн асуулт асууя.

**Ж.Энхбаяр:** Оюундарийг дэмжиж байгаа. Улс төрийн болон төрийн албаны өндөр туршлагатай, Гадаад хэргийн яамны дэд сайдаар ажиллаж байсан ийм дипломатч хүн байгаа. Тэгэхээр төрийн тэргүүний айлчлал энэ оны хагас жилд



Польш Улсад зохион байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа. Тэрний өмнө хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх үүднээс Польшийн Хөдөө аж ахуйн яамтай манай яам холбогдож ажиллаж байгаа. Энэ дээр бэлтгэл ажлыг хангах үүднээс анхаарлаа нэлээн тавиарай. Хөдөө аж ахуйн салбар нэлээн том боломж байгаа.

Нөгөө талаас манай Европоос Монгол руу гол хийгдэж байгаа худалдааны гол үүд Польш, Польшоор дамжиж Брес дээр, Беларусаар дамжиж Монгол Улс руу гол гадаад харилцаа, эдийн засгийн гол тээвэр ложистик тэнд дамжиж байгаа. Тэгээд тэнд их боомтын ажил дээр их анхаарахгүй бол тэнд их нэлээн эрсдэлүүд, хүндрэлүүд гардаг.

Нөгөө талаар Монголын олон иргэд ялангуяа манай эрүүл, уламжлалт анагаахын салбарынхан олон зуугаараа байж тэнд нэр хүнд их сайтай буюу Польш даяар их сайхан хүндлэгдсэн энэ салбарт их амжилттай ажиллаж байгаа байгаа. Тэгэхээр эднийхээ бэхжүүлэх чиглэлээр нэлээн анхаарна биз. Ганц хөдөө аж ахуйгаас гадна аюулгүй байдлын гадаад орчин олон зүйлээрээ Монгол Польшийн нөхцөл байдал ижилхэн байгаа. Тэгэхээрээ Польшийн болж байгаа үйл явдлыг бид байнга их ойрхон анзаарч, ажиглаж байх, тэд нартай олон зүйлээ хамтдаа хийж байгаагаа уялдуулж байх ийм зайлшгүй шаардлага байдаг. Тэгээд тэр чиглэл дээр аюулгүй байдлын салбарт их онцгой анхаарч, энэ тусгай албад хоорондын харьцааг бий болгох, аюулгүй байдлын гадаад орчин дээр хамтарсан дүн шинжилгээ, судалгаа хийх чиглэлээр, мэдээлэл солилцох чиглэлээрх ажлаа анхаараад чиглүүлээрэй гэхийг, хэлэхийг хүсэж байна. Баярлалаа амжилт хүсье.

**Г.Тэмүүлэн:** Энхбаяр гишүүн үг хэллээ. Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Яах вэ ер нь он гараад анхны элчин сайдын томилгоо явж байх шиг байна. Оюундарь нэр дэвшигчийг сайн мэднэ. Тэгээд ийм хүнийг бас ингэж оруулж ирж байгаа нь Гадаад явдлын яамнаас бас зүйтэй байна гэж үзэж байна. Шаардлагын хувьд бүх шаардлага хангаж байна. Ялангуяа сайшаан олон ч зүйл бол ард түмний саналыг аваад, мандат аваад энэ Улсын Их Хуралд ажиллаад бодлого тодорхойлж байсан хүний хувьд ер нь Элчин сайдынхаа яамны тэргүүнүүдийг бас иймэрхүү улсуудаар бид нар тавьж байх нь зөв юм гэж бодож байна. Аль ч талаасаа өгчихсөн.

Тэгэхгүй бол тэгээд л нэг бадарчин хийж байсан нөхрийг авчирч томилоод л тухайн улс орондоо хүндэтгэлгүй хандаж байгаагаа тэрүүгээр илэрхийлээд л байдаг бас болохгүй л дээ. Тэгэхээр Зүүн Европын үүд болсон, ер нь Европын үүд болсон ийм улс оронд ийм хүнээр томилох нь зүйтэй. Мэдээж хэрэг яаман дотроосоо ч бас залуучуудыг оруулж томилж байх ёстой. Тэрнээс биш наймаалцах маягаар тэгээд улс орны нэр хүндийг унагаасан ийм томилгоонуудыг явуулаад байж болохгүй. Энэ дээр манай Гадаад явдлын яам сайн анхаарч ажиллаж байгаад бас тэмдэглэхийе.

Ер нь бас манай гадаад явдал, гадаад харилцаа сүүлийн жилүүдэд их сайн байгаа. Тэр нь энэ олон айлчлалаар, энэ бүх юмаар илэрч гарч байна. Нэг зүйлийг бас тодруулж асуух шаардлагатай гэж бодож байна. Манайх чинь их туйлширна. Тэгээд ЗХУ гэж байх үед ер нь социалист агаарын орнуудад гэж байхад бид нар олон газраас тусламж авч байсан.

Тухайлбал, Польшоос, жишээлбэл Зөвлөлтийнхөн ажиллаж байхад 3 хүн тутмын нь Украин хүн байсан. Украинд бид нар консул сууж байсан. Одоо Варшаваас хамаарч байна уу, Польшоос хамаарч байгаа байх. Тэгээд энэ дээр бас анхаармаар байна. Украин Монголын хооронд визгүй зорчих тийм гэрээ байгаа. Энэ амьдрал дээр юу болсон бэ? Ард иргэдийн хооронд визгүй зорчих тэр юмаа Засгийн газар батлах ч гэл үү, нэг юм үлдчихсэн гэсэн. Украины талаас батлаад бүх юмнуудаа явуулчихсан байдаг. Энэ байнга дайн дажинтай байхгүй ээ. Энэ 25 оноос, 26 оноос ингээд хэвийн харьцаандаа орох байлгүй Дэлхийн ертөнц. Тэгээд тэр үед бас Украин, Польшид суралцаж байсан хүмүүс олон байдаг. Тэгээд үүгээр дамжаад явна. Энийг бид нар бэлтгэлтэй ингэж хандах ёстой гэж ойлгож байна. Энэ талаар ямар бодолтой байна вэ? Явах гэж байгаа Элчин сайд, Гадаад явдлын яам? Тэгээд энэ хэчнээн оронд бид нар визгүй болоод байна? Өнгөрсөн жил Вьетнамтай визгүй боллоо. Энэ их сайн байна. Ингээд үр дүнгүүдээ өгч байна. Цаашдаа ер нь гадаад харилцаанд бид нар тэр мөнгө төгрөг хайрлаад энэ тэр гээд ингээд байхгүй бас үр дүнтэй жижиг улс жижиг бодлого биш, угаасаа л манайх том бодлоготой байсан. Том бодлогоороо.../минут дуусав./

**Г.Тэмүүлэн:** Тэгье, Ганбат гишүүн 1 минут нэмж өгье.

**Д.Ганбат:** Энэ жил хэдэн оронд визгүй зорчдог болох вэ? Монгол паспорт маань өшөө сайжирч чадах уу гэсэн ийм асуултууд байна.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Оюундарь гишүүн эхлээд хариулъя. Нэр дэвшигч Оюундарь 2 номер.

**Н.Оюундарь:** Польш улсаас Варшавт суугаа Монгол Улсын Элчин сайдын яам 3 орныг хавсран суудаг юм байна лээ. Тэр нь Украин, Литва, Латви. Тэгээд Монгол Улс өөрөө энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг эрхэмлэж ажилладаг. Тэгээд Украинтай ч тэр, Польштой ч тэр ер нь хэл амаа нэлээд сайн ололцож явдаг. Гадаад яам хоорондын зөвлөлдөх уулзалтуудыг удаа дараа хийсэн. Харилцан өөрийнхөө байр суурийг нэлээд сайн ойлгуулсан байж байгаа. Украины хувьд. Украинд энэ Оросын дайны хувьд иймэрхүү байр суурьтай байдаг.

Польш Улс руу бол албан болон дипломат паспортоор 90 хоног визгүй зорчдог юм байна лээ. Украин руу бол энгийн паспортоор бас визгүй зорчдог. Тэгээд бусад визтэй холбоотой асуудлаар манай Консулын газраас хариу хэлчихнэ байх.

**Г.Тэмүүлэн:** Батцэцэг сайд нэмж хариулъя.

**Б.Батцэцэг:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Манайх гадаад албан дипломат паспортын үнэ цэн бол нэмэгдэж байгаа. Сүүлийн жилүүдэд бид нар нэлээн олон, сүүлийн 4 жил бараг арван гурав, дөрвөн улстай бид нар визийн харилцан чөлөөлөх хэлэлцээр байгуулсан. Одоо ч гэсэн явцын дунд 6 хэлэлцээр явж байгаа. Тэгэхээр энэ жилийн хувьд бид нар 6-8 улстай ажиллаж байгаа. Виз харилцан чөлөөлөх. Яг өнөөдрийн байдлаар бид нар энгийн паспорт эзэмшиж байгаа иргэд 30 оронд визгүй зорчиж байгаа. Албан болон дипломат паспорт эзэмшигчид нийтдээ 66 оронд визгүй зорчиж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Нэмж Батцэцэг сайд нэмж хариулъя.

**Б.Батцэцэг:** Манайх бүх НҮБ-ын гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоож дууссан байгаа өнгөрсөн жил. Украин Улстай бид нар найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бас хөгжүүлээд олон жил болж байгаа. Тэгээд сая бид нар бас олон улсын эрүүгийн шүүхтэй холбоотой асуудлаар Украинд манай дипломатууд бас очиж ажилласан байгаа Европын газрын холбогдох улсууд нь. Бид нар харилцан визгүй зорчих хэлэлцээрийг бол байгуулчихсан байгаа. Дайн болохоос өмнө. Тэгээд одоо Засгийн газраар хэлэлцүүлэх энэ процедурын юм үлдсэн байгаа. Та бас зөв мэдээлэлтэй байна. Энийг бид нар ч удахгүй визгүй болгоод шийдвэрээ Украины талд өгнө өө гэдгээ албан ёсоор Гадаад сайдад нь хэлсэн байгаа. Шинэ гадаад сайдтай нь бас танилцсан, удахгүй бас бид уулзах юм. Тэгэхээр энэ шийдвэр ойрын үед гарна гэж ойлгож болно.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу Ганбат гишүүн? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Алга байна.

Тэгэхээр санал хураалт явуулна. Гишүүд маань анхааралтай байгаарай.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдыг томилох асуудлаар санал хураалтыг явуулъя.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт сай Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай, гишүүд саналаа өгөөрэй.

Туршилтын санал хураалт явуулах уу? 1 туршилтын санал хураалт явуулаадахъя. Туршилтын санал хураалт шүү. Туршилтынх.

Болж байна гэж үзэх үү тээ. Санал хураалтыг явуулъя. Дахиад хэлье. Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Төхөөрөмж дээр 17-гоос 15 гэсэн байна. Номтойбаяр гишүүн дэмжсэнээр санал өглөө. Нийт санал хураалтад 17 гишүүн оролцоноос 16 гишүүн дэмжиж, нэр дэвшигч дэмжигдлээ.

Нэр дэвшигч Оюундарь танд бас ажлын өндөр амжилт хүсье. Ингээд дипломат албанд нэр төртэй, хариуцлагатай бас ажиллаарай гэж хэлэх байна. Мөн энэ жил дипломат, Гадаад харилцааны яамнаас томилогдсон Элчин сайд нар нийт 23 Элчин сайд нар бол бас чөлөөлөгдөхөөр эргүүлэн томилогдохоор бол байгаад байгаа.

Тэгэхээр бас гишүүдийн хэлж байгаа саналуудыг бас анхаарч үзээрэй. Эргээд энэ дипломат алба гэдэг бол өөрөө хариуцлагатай алба. Мэдээж энэ шаардлага хангасан төрийн албаны болоод Дипломат албаны тухай хуулиудын

гол нь шаардлага хангасан нэр дэвшигч нарыг бас оруулж ирээрэй гэдэг дээр бол бас Гадаад харилцааны сайдын хувьд танд бас онцгой анхааруулан бас хэлж байна. Тэгээд мэргэжлийн болон өндөр ур чадвартай, дадлага туршлагатай, наанадаж гадаад хэлний мэдлэг боловсролтой ийм хүмүүсийг оруулж ирэх даалгаврыг бас Байнгын хорооноос өгч байгаа шүү танд. Ажлын хэсэг та бүхэнд бас баярлалаа.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилох байгаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн байна уу саналаараа? Манай эмэгтэй гишүүдээс танилцуулах уу? Жаргалан гишүүн үү? Тэгье Жаргалан гишүүнийгээ томилъё. Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Ингээд дараагийн асуудалдаа орцгооё.

13.50 цаг

**Хоёр. “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.**

Засгийн газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүн орж ирж байна. Танилцуулъя Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт сайд хүрэлцэн ирсэн байна. Батлан хамгаалахын Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Ганхуяг, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Төрбатын Наранхүү, Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Гомбосүрэнгийн Энхболд, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын Олон улсын гэрээ, эрх зүй, ёслолын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Цогтсайханы Сэргэлэнбаатар гэсэн бүрэлдэхүүн өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах асуудал Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан. Монгол Улс, Япон Улс энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор хоёр талаас томилогдсон ажлын хэсэг хэлэлцээрийн төслийг эцэслэхээр тохирсон.

Хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газар 2024 оны 9 сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар зөвшилцсөнөөр уг хэлэлцээрт гарын үсэг зурах, эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамж гарч, хэлэлцээрт 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.2-т заасны дагуу болон Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах олон улсын гэрээнд хамаарах юм байна лээ.

Ийм учраас Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг заалт, Засгийн газрын тухай хуулийн, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дагуу Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан болон хуулийн төслийн үр нөлөөлөх, үнэлэх судалгааны тайлан гаргаж хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулан хуулийн төслийн үзэл баримтлалыг Гадаад харилцааны сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон бөгөөд 24 оны 12 дугаар сарын 27-ны өдөр уг хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн барьсан.

Хуулийн төсөл нь 1-хэн зүйлтэй. “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон техник шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээс соёрхон батлахаар ийм заалттай байж байгаа.

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх, батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа сөрөг үр дагавар үзүүлэхгүй, Улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Уг Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталж байгуулснаар хоёр улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, Япон Улстай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг, техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалах техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Иймд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологид шилжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,-”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Бямбацогт сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Ганбат гишүүнээр тасалъя. Батбаатар гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн асуулт асууна.

**Д.Ганбат:** Ерөнхийдөө дэмжиж байна. Гэхдээ 1 асуулт байна. Ингээд техник, технологи энэ бүх юмыг шилжүүлээд хоорондоо гэрээ, хэлэлцээ хийгээд ингээд явж болно. Үүнийг дагалдуулаад бас техник, технологийг эзэмшсэн хүн байх хэрэгтэй байх л даа, боловсон хүчин. Энэ дээр ямар байгаа вэ? Тийм, бид нар чинь газар газар л хүмүүсээ сургаад байх шиг байна. Сургах нь ч зөв. Үүнийгээ дагалдуулаад энэ техникийн мэддэг, энэ технологийн мэддэг, тэгээд энд ирээд энийгээ эзэмших энэ бүх үйл ажиллагаа чинь яаж харж байна? Энэ талаар ярьсан зүйл байгаа юу?

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тийм. Монгол Улс яг одоогийн өнөөдрийн байдлаар энэ 39 батлан хамгаалах салбарт гадаадын 39 улс оронтой харилцаа, хамтын ажиллагаатай. Яг 5 улстай цэрэг, техникийн хамтын ажиллагаатай ийм байдалтай байж байгаа. 125 улсад салбарын хэмжээнд бас их хэлэлцээр, санамж бичиг байгуулсан байгаа.

Тэгээд энэ хүрээндээ бол үндсэндээ бид нар бас зөвхөн цэрэг, техникийн хамтын ажиллагаа гэдэг дотор нөгөө зэвсэг техник авах, өгөхөөс гадна боловсон хүчнээ сургах, бэлтгэх ажил байнга орж явдаг. Япон Улсдаа бид нар бас энэ Монгол Улсын Ерөнхийлөгч 22 онд айлчилснаас хойш үндсэндээ хамтын ажиллагаа нэлээн идэвхжиж энэ хүрээнд бас хоёр улсын агаарын цэрэг хамтын ажиллагаа хийх хоёр талдаа бас харилцан бас сургалт зохион байгуулах, харилцан айлчлал хийх, мөн бас энэ хүрээндээ бас тодорхой сургалтууд явагдаж байгаа. Ер нь бол одоо үндсэндээ бас энэ техник, технологи шилжүүлэх хэлэлцээртэй холбоотойгоор бид нар бас тодорхой бэлтгэл ажлуудыг хоёр талдаа харилцан айлчлал хийж, агаарын цэргийн хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн гэдгийг бас танд хэлье. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Батбаатар:** Мэдээж цэрэг, техник, энэ батлан хамгаалах салбар, аюулгүй байдлын чиглэлээр олон улс оронтой хамтран ажиллах нь зүйтэй байх.

Гэхдээ манай иргэд дунд ч гэсэн асуудал үүсгээд л ярьж л байдаг юм шүү дээ. Гаднын цэрэг, зэвсэг Монголын нутгаар өнгөрч байна гээд л. Энэ хамтын ажиллагаанууд маань хөрш зэргэлдээ болон бусад улс орнуудтай харилцаж байхад ямар байдлаар буруу ойлгогдох, нэг талдаа, гадна талдаа бусад улс оронд, нөгөө талдаа дотооддоо иргэдэд буруу ойлголт өгдөг тэр зүйл дээр нь хэр анхаарч ажиллаж байна вэ? Иргэд их өөрөөр янз бүрийн өнцгөөр мэдээж мэдээллийн дутуу байдал юм уу, ойлголтын дутуу байдал юм уу, үгүй бол өөр бусад шалтгаанаар янз бүрийн байдлаар ярьж байхыг үгүйсгэхгүй. Тэгэхээр энэ чиглэл дээрээ бас анхаардаг баймаар байна. Энэ тухайд хийгддэг, яригддаг

зүйлүүд байдаг юм уу? Өнгөрсөн хугацаанд Монголд болсон хээрийн сургууль ч байдаг юм уу, бусад үйл ажиллагаанд их олон иргэн эмзэглэсэн. Энэ дээрээ Батлан хамгаалахын яам хариу өгч, тодорхой ийм үндэслэлтэй, ийм нөхцөл байдлууд байдаг гэдэг дээр тэр чиглэлийн ажлаа хийж байгаа юу?

**Г.Тэмүүлэн:** Батбаатар гишүүний асуултад хариулъя Бямбацогт сайд.

**С.Бямбацогт:** Түрүүн би бас хэлсэн Монгол Улсын батлан хамгаалахын гадаадын 39 оронтой цэргийн хамтын ажиллагаатай. Үүнээс 5 нь бол 5 улстай цэрэг, техникийн хамтын ажиллагаатай байгаа. Эдгээр харилцааны хүрээнд 4 улсдаа соёрхон баталсан хуультай, 16 улстай Засгийн газар хоорондын 21 хэлэлцээр хийсэн байж байгаа. Энэ хүрээндээ бид нар ОХУ, Хятад Улс, АНУ зэрэг улсуудтай бол Монгол Улсын нутагт харилцан ээлжлээд цэргийн хээрийн сургуулиудыг бас явуулдаг.

Тухайлах юм бол Хааны эрэлд сургууль бол АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтраад 2002 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд явуулж байгаа. Одоо 2 улсын хооронд анх эхэлж байсан бол үндсэндээ энэ хээрийн сургуульд 30, 40 улсын цэргийн албан хаагч нар, зэвсэгт хүчин оролцдог болсон ийм өргөн хэмжээний олон улсын сургууль болсон.

ОХУ-тай бид нар Сэлэнгэ хээрийн сургуулийг хоёр улсын нутаг дэвсгэртээ ээлжилж 1 жил нь Монголд, 1 жил нь ОХУ-д, мөн Хятад Улстай бас хээрийн сургуулийг бид нар бас Хятад Улсад 1 жилд нь, 1 жилд нь Монгол Улсад ингээд ийм байдлаар бас байнга, тогтмол явуулж байгаа.

Энэ хамтын ажиллагааг бол бас бас иргэд дэд бас зөв таниулах, ер нь бол энэ Монгол Улсын батлан хамгаалах салбарыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, энэ дотроо бас Монгол Улсын үндэсний аюулгүйн үзэл баримтлалд заагдсан улс төр дипломатын аргаар цэрэг, улс төр, дипломатын аргаар бас батлан хамгаалах салбараа хөгжүүлэх, халдашгүй байдал, бүрэн эрхт байдлаа хамгаалах энэ бодлогын хүрээнд л хийгдэж байгаа ажлууд. Энэ хүрээнд яах вэ дээ бас иргэддээ бас буруу, зөрүү ойлгох, мэдээлэл дутуугаас бас жоохон сөрөг ойлголттой болох асуудлууд гардаг. Тухай бүрд нь бид нар бол бас холбогдох зөв мэдээллүүдийг өгөх байдлаар ажиллаж байгаа.

Өнгөрсөн жил Хааны эрэлд сургууль Монгол Улсад Тавантолгойд болсон. Энэ сургуульд 40-өөд улсын зэвсэгт хүчин оролцсон. Энэ талаар мэдээллүүдийг маш сайн хүргэж иргэд нэлээн сайн ойлголттой болсон. Мөн өнгөрсөн оны 9 сард Халх голын, Халх гол Дорнодод бас бид нар бас Халх голын ойн 39, Халх голын 75 жилийн ойн хүрээнд Сэлэнгэ хээрийн сургуулийг ОХУ-тай хамтарч зохион байгуулсан. Үүнтэй холбоотой бас мэдээллүүдийг бас олон нийтэд хүргэх, таниулах, сурталчлах ажлыг бас их зөв зохион байгуулсан. Үүний үр дүнд үндсэндээ бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа энэ хээрийн сургуулиудтай холбоотойгоор тийм сөрөг ойлголтууд гарах нь багасаж байгаа. Цаашдаа ч гэсэн энэ бүхэнд бид бас анхаарч ажиллана.

Ер нь бас дэлхийн улс төр, геополитик нөхцөл байдал бол нэлээн тийм амаргүй болж байгаа үед улс орон болгон бас өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангах, энэ батлан хамгаалах салбараа бэхжүүлэх, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх талд онцгой анхаарч байгаа. Эндээс ч гэсэн Монгол Улс хоцрохгүй байх ёстой. Ингэхийн тулд бас бүхий л бас арга чаргаа хэрэглэх ёстой. Энд бас

энхийг сахиулах ажиллагаанд оролцох, мөн бас олон улстай харилцаа үүсгэх гэх мэтээр бид Судан Улс болон олон улсад манай Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн албан хаагч нар бас энхийг сахиулах ажиллагаанд оролцож энэ улсынхаа батлан хамгаалах салбарыг бэхжүүлэх тодорхой үүрэг рольтой байгаа. Энэ байдлаараа бид бүхэн бол бас нэлээн ач холбогдолтой ажлуудыг л хийж, хэрэгжүүлж байгаа гэж ойлгож байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байгаа юу?

Алга байна.

Санал хураалтыг явуулж эхэлье. “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Гишүүд болгоомжтой байгаарай, анхааралтай байгаарай. Анхааралтай байгаарай. Санал хураалтыг явуулъя.

82.4 хувиар дэмжигдлээ.

Энхтүвшин гишүүн дэмжлээ. Нийт санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжсэн байна. Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүн Энхтүвшин гишүүн танилцуулах уу? Тэгье. Ингээд нэгдсэн хуралдаанд Энхтүвшин гишүүн илтгэнэ.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэгт бас баярлалаа.

14.03 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Д.ОТГОНДЭЛГЭР**



